"'ПАТРИКЕЙН" ХХК-ИЙН ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ "ТӨМӨР ЗАМЫН АЧИЛТ БУУЛГАЛТЫН ТАЛБАЙ" ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

(Регистрийн дугаар – 5512778)

ХЯНАСАН:

ХБОБХГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН:

"ПАТРИКЕЙН" ХХК ЗАХИРАЛ MA GUOQING

"ПАТРИКЕЙН" ХХК
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН О.АЗЗАЯА

УЛААНБААТАР 2024 ОН

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 5
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ 7
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 9
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 10
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ . 15
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 16
8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 17
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ 20
10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 21
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 25

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 10
Хүснэгт 2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....15
Хүснэгт 3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....17
Хүснэгт 4. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний биелэлт.....20
Хүснэгт 5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт 21
Хүснэгт 6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт.....25

Зургийн жагсаалт

Зураг 1. Төсөл талбайн байршлын зураг 3

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: “Төмөр замын ачилт буулгалтын талбай” төсөл

Төсөл хэрэгжүүлэгч: “Патрикейн” ХХК /улсын бүртгэлийн дугаар-9011728141, регистрийн дугаар: 5512778, хаяг: Улаанбаатар, Сүхбаатар 1-р хороо,4 давхар Утас: 99999169, 99085676/

Төслийн байршил: “Патрикейн” ХХК нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутаг дэвсгэрт Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн А/103 тоот шийдвэрийг үндэслэн нэгж талбарын 4201007067 дугаар бүхий 20 га, 000310307 газар эзэмших эрхийн гэрчилгээг үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшдэг. Төсөл хэрэгжих талбай нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р баг Аяган-100 тоот газарт, 20000 м.кв газар дээр төмөр замын ачих, буулгах талбайн зориулалтаар ашиглан байрлаж байна.



Зураг 1. Төсөл талбайн байршлын зураг

Төслийн хүчин чадал: Төмөр замын ачилт буулгалтын талбай нь “УБТЗ” ХНН-ийн Чойр өртөөнөөс баруун тийш салбарласан Р50 маягийн, 1/9 маркийн суман шилжүүлгийн хамт 1741 м урт төмөр зам байгуулахаар төлөвлөсөн ба жилийн турш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулна.

“Патрикейн ХХК”-ийн салбар төмөр зам:

- Зориулалт- Чойр өртөөнөөс ачиж буулгах талбай хүртэлх холбох зам
- Гар удирдлагатай
- Ачилт буулгалтын 1-р зам 417.72м
- Ачилт буулгалтын 2-р зам 387.33м
- Татах 3-р зам 87.50м
- Тахирын эхлэл ПК-0+37.31
- Тахирын төгсгөл ПК 6+29.90
- Хязгаарын шон 300м
- Призмын ёроол 75м

Цахилгаан хангамж: Цахилгаан эрчим хүчээ "УБТЗ" ХНН-ийн эрчим хүч ус хангамжийн 2-р ангитай гэрээ байгуулан эрчим хүчний шугамаас татсан байна.

Ариун цэврийн байгууламж: Төсөл хэрэгжүүлэгч Патрикейн ХХК нь үйл ажиллагааны явцад ялгарах шингэн хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөө учруулахгүй байх зорилгоор төслийн талбайд бетонон кольцо бүхий био ариун цэврийн байгууламжийг шийдэж өгсөн байна.

Дэд бүтэц: Тухайн төслийн хувьд ачилт буулгалтын талбай нь Чойр өртөөнөөс баруун тийш салбарласан Р50 маягийн, 1/9 маркийн 879.32м урт төмөр замаар бараа тааваарыг ачиж, буулгах ба жилийн турш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулна. Талбайд дараах обьектууд байрлана. Үүнд:

- ✓ Чойр өртөөнөөс салбарласан 1 салаа 879.32м, Р50 маягийн төмөр зам
- ✓ Өндөр тавцан
- ✓ Ачилт буулгалтын талбай
- ✓ Авто болон вагон пүү
- ✓ Пүүний ажлын байр
- ✓ Ажилчдын амралтын байр зэрэг байрлана.

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүйн нөхцөл: Далайн түвшнээс дээш 1000-1500 м өргөгдсөн. Физик газарзүйн хувьд тал хээрийн мужид, геоморфологийн хувьд говь, хээрийн бүсэд багтах бөгөөд улаан хүрэн шавранцар хөрстэй.Газар хөдлөлийн эрчим 7 балл.Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр, мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой.

Хөрс, хөрсөн бүрхэвч: Хөрс-газарзүйн мужлалтаар нутгийн хойт хэсэг нь Төв Азийн их мужийн Хангайн мужийн өргөрөгийн бүсийн хүрэн хөрсний бүсийн 2-р тойрог, нутгийн өмнөд хэсэг нь Говийн мужийн өргөрөгийн бүсшилийн цайвар хүрэн хөрсний дэд бүсийн 4-р тойрог, цөлөрхөг хээрийн бор хөрсний дэд бүсийн 6-р тойргуудад тус тус хамрагдана Хүрэн хөрс манай оронд хамгийн өргөн дэлгэр тархах бөгөөд газарзүйн байрлал гарал үүслийн хувьд нугат хээрийн хар шороон хөрснөөс цөл хээрийн бор хөрсөнд шилжих завсрын шинж чанартай юм. Монгол оронд тархсан хүрэн хөрсийг газарзүй гарал үүслийн онцлогоор нь тал хээрийн хүрэн хөрс¸уулт хээрийн хүрэн хөрс¸нугат хээрийн хүрэн хөрс гэж үндсэн 3 бүлэгт хуваж болно.

Ургамлан нөмрөгийн төлөв байдал: Нутгийн баруун хойд талаар хялгана, харгана, баруун емнед талаар бударгана дэрс, зэрэг голлосон тойрмын ургамал голлох бегеед бэлчээрийн евел хаврын даац нь дунджаар 08-1,0 центнер га, зун намрын даац нь 2,5-3,0 центнер га-гийн неецтэй тул 80,0 мянгаас илуу малыг бэлчээрээр ха нгах боломжгуй юм. Бэлчээрийн хувьд хялгана- харгант, хазаар өвс – хялгант, хиаг – хялгана – хазаар өвст соргог өвст бэлчээр бүхий хуурай хээр зонхилж, хялгана(говийн)- таана – баглуурт, хялгана– хазаар өвст – агьт, хялгана – боролзой – шарилжит, хялгана – харгана, таана– хялганат, таана – улалж, бударгана – шарилжит, дэрс – бударгант, бор шавагт, бударгана – хармагт цөлийн хээр зонхилдог байв. Хужиртай байдам (нуга шавартай) газарт таана-улалж, улалж – зурман сүүлт, ахар сорт арвай – марцны цэгээлж – ширэг зонхилно.

Уур амьсгалын ерөнхий төлөв: Халуун нь +32 хэм хүртэл дулаарах хандлага тохиолддог. Жилдээ 200-250 мм хур тунадас унадаг нь Говийн бүсийн дунджаас илүү юм. Уур амьсгалын хувьд хуурайдуу сэрүүвтэр. евлийн улиралд хамгийн хуйтэн нь -33 хэм, зуны улиралд Хонь, тэмээ, үхэр, ямаа, адууны аж ахуй эрхлэхэд нэн тохиромжтой. Хаврын өдрийн урт 10 цагаас бага, цэлмэг өдөр 7 өдрөөс бага, бүрхэг өдөр 5-аас бага, зуны өдрийн урт 10 цагаас бага, зуны бүрхэг өдөр 5-аас бага, цэлмэг өдөр 3-аас их, намрын өдрийн урт 8 цагаас бага, бүрхэг өдөр 3-аас бага, цэлмэг өдөр 13- аас бага, өвлийн өдрийн урт 7 цагаас бага, Өвөлд орох цасны дундаж хэмжээ 10 см-ээс бага, цас

тогтох хугацаа 11-р сарын 21 12-р сарын 1, цас арилах хугацаа 3-р сарын15 хүртэл үргэлжилдэг. Салхины хамгийн их хурд 25 м/секунд. Салхины чиглэлийг авч үзвэл 1-р сарын Розагаар хойд, баруун хойд, зуун зугийн салхи голлодог. Салхигуй тохиолдол 22 хоног. Салхины дундаж хурд нь хойд зүгийн салхи 2-4 м/ сек, баруун хойд зүгийн салхи 4-6 м/ сек, баруун хойд зүгийн салхи 2-4 м/ сек байдаг. 7-р сарын салхины розаг авч үзвэл салхигуй хоног 21, хойд зугийн салхи 18 м/сек, баруун хойд зугийн салхи 4-6 м/сек, зуун хойд зугийн салхи 2-4 м/сек, баруун урд зугийн салхи 2-4 м/сек байдаг. Аймгийн нутагт хуйтэвтэр хоногийг авч узвэл хамгийн олон нь 122, хамгийн цөөн нь 95 хүйтэрдэггүй хоног 80-100 байдаг. Энэ нь байгаль цаг уурын хувьд гадаадын иргэд ажиллаж амьдрахад тохиромжтой нөхцөл юм.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Ачаа бараа ачих болон буулгахад гарах тоос
- Ачаа бараа тээвэрлэж ирэх автомашинаас ялгарах хорт хий
- Галт тэрэгнээс ялгарах хорт хий болон дуу чимээ
- Зам барилгын ажлын үед гарах тоос
- Ачилт буулгалтын талбайд тээврийн хөдөлгөөнөөс гарах тоос зэрэг болно.

Автотээврийн хэрэгсэл болон бусад төхөөрөмжийн дуу чимээ болон хорт хий утаа гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө. Үүнээс гадна барилга угсралтын үйл ажиллагаа болон тээврийн хөдөлгөөнтэй холбоотойгоор агаарын бохирдол үүсч болзошгүй. Төлөвлөж буй төслийн барилгын үйл ажиллагааны явцад тоосжилт, тухайн бүс нутгийн уур амьсгалын нөхцөлтэй уялдан их, бага хэмжээгээр үүсэх учраас энэ асуудлыг зайлшгүй авч үзнэ. Төсөл хэрэгжих орчны хуурай уур амьсгал, хүчтэй салхи шуурга зэрэг нь төслийг төлөвлөх болон хэрэгжүүлэх шатанд холбогдох зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй бол ихээхэн хэмжээний тоосжилт орчиндоо бий болгох нөхцөлтэй.

Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөлийн эх үүсвэр нь төслийн талбайд баригдах барилга байгууламж, овоолго, ажилчдын тосгон, хүнд даацын машины хөдөлгөөн, антропогений хүчин зүйлс зэрэг юм.

- Төмөр замын ачих буулгах талбайн төслийн 5 жилийн хугацаанд нийт 0.35 га талбай өөрчлөлтөнд орж хөрсөн бүрхэвч нөлөөлөлд өртөхөөр байна. Төслийн хүрээнд төлөвлөж буй барилга байгууламжид хөрс удаан хугацаанд дарагдана. Түүнчлэн дэд бүтцийн барилга, байгууламжийн ойр орчимд машин техник, хүний үйл ажиллагаагаар элэгдэл, эвдрэл, бохирдол үүснэ. Төслийн үйл ажиллагааны явцад машин техникийн эвдрэл гэмтэлээс үүдэн тос, тослох материалын асгаралт, шүүрэлтээс хөрс бохирдох боломжтой.
- Техникийн хөдөлгөөнөөс хучилтгүй -зам талбайн хөрс элэгдэж, эвдрэх, ургамлан нөмрөг талхлагдах
- Ачиж тээвэрлэх, буулгах явцад гарах тоос хөрсөн дээр хаягдсанаар хөрсний шинж чанар өөрчлөгдөх

- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяаагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох
- Ахуйн бохирын усыг шаардлагын хэмжээнд хүртэл цэвэрлэж шүүгээгүй тохиодолд шууд гадагшлуулж байгальд хаях нь хөрс бохирдуулах нэг эх үүсвэр болох талтай.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

Төсөл хэрэгжих явцад байгалийн усны нөөц болон усны бохирдолд үзүүлэх нөлөөлөл нь төдийлэн эрчимтэй бус юм. Гэвч ахуйн бохир ус болон хог хаягдлыг зөв байршуулаагүй мөн орчны цэвэрлэгээ хийгээгүйн улмаас гадаргын болон газрын доорхи ус, хөрсний ус бохирдуулж болзошгүй.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны 2024 оны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний менежментийн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах зэрэг арга хэмжээнүүдийг тус тус хэрэгжүүлсэн байна.

Мөн Монгол улсын "Байгаль орчныг хамгаалах тухай" болон "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А/618 тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам" зэргийг удирдлага болголоо.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний менежментийн төлөвлөгөө, орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах зэрэг ажлууд багтсан бөгөөд 2.772 сая.төг зарцуулахаар төсөвлөсөн байна.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар	Гүйцэтгэл
1	Галт тэрэгний зүтгүүрийн хаягдал утаа агаар орчныг бохирдуулах Төслийн талбайд ахуйн хог хаягдлын сав, бохир ус дамжуулах хоолой болон бохир ус цуглуулах хэсгийн битүүмжлэл муу байснаас үнэрийн бохирдол үүсэх	Хог хаягдлыг битүү саванд хуримтлуулж тухай бүрт нь хогийн цэгт хаях	Бүрэн хэрэгжсэн	Хог хаягдлын савыг зориулалтын битүү тагтай, ангилан ялгахаар хийж байршуулсан.	
2		Тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод зам талбайг услахдаа тоос дарагч бодис ашиглах	Бүрэн хэрэгжсэн	Тоосжилт дэгдэх бороо ороогүй, салхи ихтэй үеүдэд зам талбайн усалгааг тогтмол хийж гүйцэтгэсэн.	

3		Орц гарцын орчмын талбайг хайрган хучилттай болгож агаарт тоос, тоосонцор тархахаас сэргийлэх	Бүрэн хэрэгжсэн	Төслийн талбайн орц, гарцыг хайрган хучилттай болгон сайжруулсан.	

4	Төмөр зам тавих барилгын ажлын үе шат, автомашины хөдөлгөөн зэргээс хөрс элэгдэл, эвдрэл үүсэх	Автомашины зогсоол, дотоод зам талбайг хатуу хучилттай болгох	Бүрэн хэрэгжсэн	Төслийн талбайн автомашины зогсоол, дотоод зам талбайг тэмдэгжүүлсэн	

5	Хог хаягдал, бохирын шингэн алдагдсанаас хөрсөнд бохирдол үүсч болзошгүй	Хог хаягдал бохирыг төвлөрсөн цэгт хаях	Бүрэн хэрэгжсэн	Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх гэрээг “Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ”-тэй байгуулан жил бүр сунгуулан ажиллаж байна.	 

6	Ашиглагдаж буй машин тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ	Олборлолтын ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх	Бүрэн хэрэгжсэн	Төслийн ажлыг өдрийн цагаар хийж гүйцэтгэж байна.	

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Хэрэгжилт	Тайлбар	Гүйцэтгэл
1	Газар ашиглалтанд өртөөгүй буюу үйл ажиллагаа явуулахгүй байгаа талбайд зүлэгжүүлэлт хийх	-	-	Бүрэн хэрэгжсэн	Мод, бут тарихдаа мэргэжлийн байгууллагаас заавар, зөвлөмж, сургалт, авч орон нутгийн хөрс болон цаг агаарын онцлогт тохирсон мод бут тарих шаардлагын дагуу төслийн талбайн үүдэн хэсэгт өмнө жилүүдэд болон энэ жил тарьсан моддын арчилгааг усалгаа, тордолгоог цаг тухай бүрт хийсэн. Мод үржүүлгийн мэргэжлийн байгууллага болох “Бат дэм ббн” ХХК-аас сургалт зөвлөгөө авч 1000 ш хайлаас тарьсан.	
2	Нөхөн сэргээлтэд тухайн бүс нутгийн унаган ургамал, мод бутыг ашиглах	10	$м^2$	Бүрэн хэрэгжсэн		
3	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд аймаг орон нутгийн зааж өгсөн газар мод тарих	50	ш	Бүрэн хэрэгжсэн		

4	Бүхий л арга хэмжээг авах, шаардлагатай объектуудад хашаа барих	-	$м^3$	Бүрэн хэрэгжсэн	Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, төслийн талбайн гадуур нилэнхүйдээ бетонон хашааг хийсэн бөгөөд цамхагийг тойруулж хашаа хийж гүйцэтгэсэн. Төслийн талбайн камержуулалт болон нийтийн эзэмшлийн зам талбайг харуулсан камержуулалтыг хийж гүйцэтгэсэн. Төслийн орц гарцын хэсэгт олон улсын стандартад нийцсэн цахим бүртгэлийн системийг нэвтрүүлэх ажлуудыг хийж орчны тохижилтыг хийж гүйцэтгэсэн.	

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Патрикейн” ХХК-ийн төслийн талбайд палеонтлогийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна. Үйл ажиллагааны явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулна.

8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул, осол,сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар	Гүйцэтгэл
1	Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх гарын авлагатай болох	Бүрэн хэрэгжсэн	Болзошгүй осол эрсдэлээс сэргийлэх арга хэмжээний гарын авлага, зөвлөмжийг ажиллагсдад өгч ажилласан.	
2		Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбартай байх	Бүрэн хэрэгжсэн	Болзошгүй осол эрсдэлээс сэргийлэх, осол эрсдэлийн үед авах арга хэмжээний талаар ажилчдад сургалт өгч ажилласан.	
3		Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох	Бүрэн хэрэгжсэн	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэл , тоног төхөөрөмжийг байршуулсан.	
4		Болзошгүй аюул ослын үед ашиглах мөнгөн хуримтлал бүрдүүлэх	Бүрэн хэрэгжсэн	Болзошгүй аюул ослын үед ашиглах мөнгөн хуримтлал бүрдүүлсэн.	

5	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх,байгалийн гамшиг	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Бүрэн хэрэгжсэн	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгаж ажилласан.	
6		Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Бүрэн хэрэгжсэн	Осол эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ, урьдчилан сэргийлэх, гамшгийн авах арга хэмжээний талаар ажиллагсдад сургалт зохион байгуулсан.	

7	Эрүүл мэнд	Ажилчдыг жилд 2 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Бүрэн хэрэгжсэн	Ажилчдыг Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.	

Говьсүмбэр аймгийн нэгдсэн эмнэлэг

Шинжилгээний хариу

Эмнэлгийн хаяг: ***Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 1-р баг***

Утас: *70543392* Вэб: *www.govisumberne.mohs.mn*

Эмч/Эх/ийн нэр ***Оюунбаатар*** Нэр *Эрдэнэчимэг* *нас:* *41* *хүйс:* эм

Регистрийн дугаар *ЕЙ83041705* Тасаг:

Шинжлэгдсэн	Харуу	Нэгж	Лавлах хэмжээ	Анхааруулга
Нян судлал	Илгээсэн:Ж.Болдбаатар			
				Мазок эм
Баркод: **42130036** Сорьц: **Утрэний**	Сорьц ирсэн огноо		Хариуны огноо	2024/01/30
Хумуур эс	1-2		---	
Цагаан эс	17-25		---	
Саас	-		---	
дифтеррок	-		---	
Трихономус	-		---	
Мөөг	-		---	
Тулхуур эс	+		---	
Хламид	-		---	
кокк	3		---	Н
Лактобацил	4		---	Н
Мобилункус	-		---	
Нийт	7		---	Н

Хийсэн: ***Г.Наранцэцэг*** Баталгаажуулсан: ***Д.Мөнхцацрал*** 2024/01/30 14:48

Тайлбар:

Хэвлэсэн: 2024/06/10 16:13

9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний биелэлт

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хэрэгжилт	Тайлбар
		Хөрсний шинжилгээ		
1	Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Төслийн талбайд 2 цэг сонгох /ажилчдын байр, ачих буулгах талбай орчим/	Бүрэн хэрэгжсэн	Хөрсний агрохими, механик бүрэлдэхүүний дээжийг хөрсний зүсэлт хийж дээж авч шинжлүүлсэн.
2	Хүнд металлын агууламж	2 цэгт /ажилчдын байр, ачих буулгах талбай орчим/	Бүрэн хэрэгжсэн	Хөрсний хүнд металлын дээжийг хөрсний зүсэлт хийж дээж авч хөрс судлалын лабораторид шинжлүүлсэн.
		Усны хяналт шинжилгээ		
3	Усны чанар pH, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Унд ахуйн усыг хангаж буй уснаас	Бүрэн хэрэгжсэн	Унд ахуйн усыг хангаж буй уснаас усны шинжилгээг авч лабораторид шинжлүүлсэн.
		Агаарын чанар, дуу чимээ		
4	Тоосжилт (PM10, PSM, PM25); Гадаад дуу чимээ, Ажлын үзүүлэлтүүд гэрэлтүүлэг, чийгшил физик бохирдлын түвшин); Бохирдлын цэгэн эх үүсвэр (O2, SO2, NO2, CO)	Төслийн талбай болон орчны бүсэд болон дотоод орчны доргио, чичиргээ; байрны эрүүл ахуйн (тоос, дуу чимээ, болон	Бүрэн хэрэгжсэн	Тоосжилт (PM10, PM25); дуу чимээ,доргио,чичиргээний шинжилгээг шинжлүүлсэн.

10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар	Гүйцэтгэл
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах	Бүрэн хэрэгжсэн	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, Засгийн газрын 2011 оны 311 тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д заалтыг хэрэгжүүлж, 2024 оны 10 сарын 28-ний өдрийн дотоод журмыг боловсруулж хэрэгжүүлж байна.	
2	Байгаль орчныг хамгаалах, осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар жилд 2 удаа сургалт зохион байгуулах	Бүрэн хэрэгжсэн	Байгаль орчныг хамгаалах, болзошгүй осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр “Патрикейн” ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Баатардалай ажилчдад сургалт, танин мэдэхүйн арга хэмжээ зохион байгууллаа.	

3	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө	Бүрэн хэрэгжсэн	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 04 сарын 15-ний өдөр боловсруулж ажиллагсдад хяналт тавьж ажилласан.	
4	Бүх ажилчидыг жилд 2 удаа эмчийн үзлэгт хамруулж байх	Бүрэн хэрэгжсэн	Бүх ажилчидыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.	 **Говьсүмбэр аймгийн нэгдсэн эмнэлэг** Шинжилгээний хариу Эмнэлгийн хаяг: ***Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 1-р баг*** Утас: *70543392* Вэб: *www.govisumberne.mohs.mn* Эмч/Эх/ийн нэр ***Оюунбаатар*** Нэр *Эрдэнэчимэг* *нас:* *41* *хүйс:* эм Регистрийн дугаар: *ЕЙ83041705* Тасаг: Шинжлэгдсэн үүн: Хариу: Нэгж: Лавлах хэмжээ: Анхааруулга **Нян судлал** Илгээсэн:Ж.Болдбаатар **Мазок эм** Баркод: **42130036** Сорьц: **Ураагийн** Сорьц ирсэн огноо: Хариуны огноо: 2024/01/30 *Хүчтэй эс* 1-2 --- *Цагаан эс* 17-25 --- *Салс* - --- *диплоккок* - --- *Трихономус* - --- *Мөөг* - --- *Тунхүүр эс* + --- *Хламид* - --- *кокк* 3 --- Н *Лактобацил* 4 --- Н *Мобилюнкус* - --- *Нийт* 7 --- Н Хийсэн: ***Г.Наранцэцэг*** Баталгаажуулсан: ***Д.Менхцацрал*** 2024/01/30 14:48 Тайлбар: . Хэвлэсэн: 2024/06/10 16:13

5	Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах сургалт зохион байгуулах, галын аюулгүй ажиллагааны талаар дүүргийн ГТТХХэлтэстэй хамтран галын аюулаас урьдчилан сэргийлэх үзүүлэх сургууль хийх	Бүрэн хэрэгжсэн	ХАБЭА-н сургалтыг зохион байгуулсан.	
6	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	Бүрэн хэрэгжсэн	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулсан.	

7	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах	Бүрэн хэрэгжсэн	Шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангаж ажилласан.	
8	Байгаль орчны аудитын тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Бүрэн хэрэгжсэн	Байгаль орчны аудитын тайланг байгаль орчны аудитын тусгай зөвшөөрөл бүхий “Агьлиш” ХХК-тай 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр гэрээ байгуулан хийлгэж байна.	
9	Газрын төлөв байдал чанарын хянан баталгааны тайлан хийлгэх	Бүрэн хэрэгжсэн	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайланг 2020 онд “Экситос”ХХК-аар хийлгэсэн.	

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

№	БОМТ, БОМТ-ийн хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Тайлбар
1	БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нөлөөллийн бүсийн иргэд болон ажлын хэсэгт танилцуулах	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	2024 оны БОМТ-ийн биелэлтийн тайланг боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А/618 тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын дагуу 11 дүгээр сарын 01-ний дотор хүлээлгэн өгч ажиллаж байна.
2	Аймгийн БОАЖГ-т танилцуулах	Уулзалт, санал асуулга		